

41. Монголчууд одоо болтол дөрвөн зүг найман зовхис гэж хэлдэг юм. Зовхи бол булан, өнцөг гэсэн утгатай болно.
42. Ма Чэншо «Ухуань хийгээд Сяньби» 3-5т Шанхай: АХХ 1962
43. «Ляо улсын түүх» 116-р боть 1974. Хятадын Намын Товчоо 1534т
44. Түрэг үсгийн «Билгээ хааны хөшөө» Ар талын 28-33-р мөр
45. 1225 оны үед бичигдсэн «Есүнгэйн чулуун бичиг»-т буй. мөн «Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд» 5т Үндэсний Хэвлэлийн Хороо 1983.

ЖУЖАНЫ ХААНТ УЛС, ТҮРЭГИЙН ЭЗЭНТ ГҮРЭН
/IY-YII зуун/

Академич Н.Ишжамц

IY-YII зууны үед Ар Монгол буюу өнөөгийн Монгол улсын дэвсгэр нутаг дээр оршин тогтнож байсан Төв Азийн нүүдэлчин Жужан, Түрэг улсуудын түүх, амьдрал хөгжлийн талаархи гол сурвалж бичиг баримтууд дундад зууны Хятадын угсааны төрүүдийн түүхийн сударт нэлээд байдаг. Мөн түрэг, перс, араб, унгар хэлний ном зохиолд зарим баримт, мэдээ байдаг. Сүүлийн зуу гаруй жилд Монгол, Хятад, Казахстан, Тува, Кыргыз, Унгар зэрэг улс орнуудын нутаг дэвсгэр дээр хийсэн археологийн шинжилгээгээр Түрэгийн холбогдолтой маш чухал баримт олдсоор байна. Хятад, Унгар, Монголоос авах Жужаны холбогдолтой археологийн баримт бас нээгдэж олдов. Тэр бүхэн Жужан, Түрэгийн талаархи бидний мэдлэгийн гол суурь болж байна.

Харин Жужан¹, ялангуяа түрэгийн² холбогдолтой судалгааны зохиол тэдгээрийн дотор орсон баримт материал, судалгаа шинжилгээ, дэвшүүлсэн санаа дүгнэлтүүд маш сонин бөгөөд чухал.

Жужан, Түрэгийн түүхийн баримт, тэдгээрийн холбогдолтой судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан Жужаны хаант улс, Түрэгийн эзэнт гүрний түүхийн тоймийг зураглан гаргаж болох боломжтой байна.

1. Жужаны хаант улс

Дорно Өрнийн суурьшмал иргэншилт улс гүрнүүдийн хооронд Ази-Европын нүүдлийн соёлт улс түмнүүд эрт үеэс оршин амьдарсаар ирсэн юм. Евро-Азийн зүүн хэсэгт ману-түнгүс угсааны улс аймгууд, баруун хэсэгт нь Түрэг угсааны улс аймгууд оршин амьдарч байсан бол тэдний хооронд төв хэсэгт нь гол төлөв монгол угсааны улс аймгууд оршин амьдарч байв.

Хянганы нурууны зүүн талаас Алтайн баруун бие хүртэлх өргөн уудам Монгол нутагт I зууны үед үүсэн мандсан өвөг монгол угсааны Сяньби улс III зууны үеэр задран мөхсөн. Тэдний нэг хэсэг нь Ар Монгол буюу одоогийн Монгол улсын нутаг дэвсгэр дээр үлдэж, нөгөө хоёр хэсэг нь Өвөр Монголын нутагт III зууны сүүлч, IV зууны эхээр Муюн, Тоба улсуудыг байгуулжээ. IV зууны дунд үеэр Тоба улс нэлээд хүчирхэг болж, Ар Монгол дахь Сяньби, мөн тэдний нэг салаа болох өвөг монгол угсааны Жужан аймгууд болон түрэг угсааны Гаоюй-Уйгур, тэглэ зэрэг овог аймгуудыг эзлэн захирчээ. IV зууны эцэст Тоба улс нь Умард Хятадын зарим нутгийг байлдан эзэлж, Пинчэн /Датун/ хотод нийслэлтэй Тоба Вэй улс болжээ. V зууны сүүлчээр Тоба Вэй улс эртний Хятадын нийслэл Лоян хотыг эзэлж, тэнд нийслэллэх болж, Хятадын соёлд гүнзгий орсон байна. Тоба Вэй улс түүний дараа Юань Вэй улс болж 100 гаад жил оршин тогтнож байгаад 581 онд мөхсөн юм.

IV зууны үед манай улсын нутгийн төв хэсэгт Жужаны аймгууд, түүний залгаа умард хүннү нарын үлдэгдэл³, хамгийн хойд хэсэгт гаргюй буюу уйгур овог аймгууд, нутгийн зүүн, зүүн өмнөд хэсэгт Сяньбигийн зарим овог аймаг, Алтайн өмнө тал, баруун урд Ашина овгийн зүүн түргүүд, баруун хойд хязгаарт динлин зарим овгууд болон Тагнын урианхай хэмээх тува нарын өвөг дээдэс оршин амьдарч байв. Тэдний дундаас Тоба улсын захиргаанд байж, адуу, булга, суусраар алба барьдаг байсан Жужан нар товойн гарч, зонхилох үүрэг гүйцэтгэх болж иржээ. Жужан гэсэн нэрийн тухайд бол иймэрхүү нэртэй улс аймгийн нэр хятадаар тэмдэглэгдэж үлдсэн нь тэр юм. Жужан гэдэг нэрийг нанхиадач-японч эрдэмтэн хатагтай Ц.Хандсүрэн монголын «зузаан /эрт, дундад үеийн жужаган жужаан гэсэн үг байж магад» хэмээн буй. Жужан гэсэнтэй ихээхэн төстэй овог аймгийн нэр хожмын үеийн монгол угсааны овог аймгуудын заримд тааралддаг. Тухайлбал, буриад-монголчуудын нэг овог нь жүнжэн гэгддэг байжээ. Тэр нь Жужан гэсэн нэр, ялангуяа түүнийг зарим хятад сударт Жүаньжуань гэж тэмдэглэдэг байсантай төстэй байгаа юм.

Жужан нарын дунд Чоуну, Датан гэх мэт хүмүүс, овог аймаг⁴ байсны нэр нь хожмын монголын Чинуа-Чоно, татар гэсэн нэрнүүдтэй төстэй байна. Хаадынх нь цолны нэг нь «Фүгүзун-Каган» гэж байжээ. Тэр нь монголоор «Бүгүдэ-ийн хаган» - «Бүгүд-ун хаган» гэсэн үг мэт сэтгэгдэл төрүүлжээ.

IV зууны дэд хагаст Жужан нарын дунд Тоба Вэй улсын ноёрхлын эсрэг тусгаар тогтнолоо сэргээх хөдөлгөөн гарчээ. Түүнийг урьд нь Мугулюй гэдэг хүн толгойлжээ. Түүний нэрийг зарим эрдэмтэд монгол гэсэн үгтэй холбож үздэг. Зарим хүн түүнийг монгол нэр мөн боловч яг монгол гэсэн үг биш, учир нь Хятадын түүх сударт «мухурн мухар» толгойдоо гээг үсгүй, тачир үст

толгойтой гэсэн утга бүхий үг гэж тайлбарласан байдаг гэж үзсэн байдаг. Үнэхээр, XIII зууны эхээр байгуулагдсан Монголын үндэсний нэгдсэн тулгур төрийн ерөнхий сайдын нэр нь Мухулай гэж байсан, тийм нэртэй монгол хүн XIII-XIV зууны үед ганц биш байсны дээр Мухулай гэсэн нэр, үг одоогийн монгол хэлэнд яг тэр утгаа хадгалан байгаа. Тийм учир Мугугюйн нэр нь монгол гэсэн нэр биш, харин мухар гэсэн тэмдэг үгээс үүссэн Мухулай гэсэн монгол нэр үг мөн гэлтэй.

Мугулюйн тэмцлийг түүний хөвгүүн Гюлухай залгамжилан үргэлжлүүлж, аймгуудаа удирдан тэмцэж, Тоба Вэй улсын ноёрхлыг нэлээд сулруулж, Жужан нарыг харьцангуй биеэ даасан байдалтай болгосон боловч бүрэн чөлөөлж чадсангүй. Түүний үед Жужан нар говийн өмнө талд нүүж очиж өвөлжөөд говийн хойно Ар Монголын нутагт ирж зуншдаг байжээ.

Гагцхүү IV зууны эцэс V зууны эхээр Шэлүнь ноён тэргүүтэй Жужан нар Тоба Вэй улсын захиргаанаас гарч, говийн хойд талд байнга нутаглан бусад овог аймгуудыг ноёрхох болжээ. Тэгээд Шэлүнь Хангайн нуруу, Орхоны хөндийд мөмө хот нэртэй өргөө ордон барьж нийслэллэн Жужаны хаант улсыг үндэслэн байгуулж, биеэ жужаны Дэүдай каган / хаан/ хэмээн өргөмжилжээ. Эндэх « дэүдай» гэсэн үг түүний хаанчлалын цол бөгөөд Жужаны хаант улсын дараачийн хаад ч янз бүрийн оны цолтой байдаг болсон байна. Дэүдай хэмээхийг хятадын түүх сударт давхиут харваач гэсэн утгатай гэж тайлбарласан байдаг байна. Зарим монгол хүн Дүүдий, Дүүдэй гэсэн нэртэй байсаар ирсэн, одоо ч тийм нэртэй эрэгтэй, эмэгтэй хүн нэг биш байгаа.

V зууны эхний арваад жилийн дотор Жужаны хаант улс Сэлэнгийн дунд урсгал, Хүнүй гол орчимд байсан Хүннү нарын үлдэгдэл нэгэн хүчирхэг аймаг, түүний хойт талд байсан гаогюйгур нар болон ойр хавийн монгол, түрэг угсааны олон овог, аймгуудыг эзэлж, нэлээд хүчирхэг улс болжээ. Тус улсын дэвсгэр нутаг ихээхэн өргөжиж, Солонгосын⁵ зүүн хойт хилээс Синьцзяны хойт тал, Хятадын цагаан хэрмээс Байгал нуурын хоорондох бүх газар нутгийг хамарчээ. Энэ нь нэгэнт Шэлүнь хааны үед Жужан улс өмнө зүгийн Тоба Вэй улстай зарим талаар өрсөлдөх чадалтай болгоно гэсэн үг. Тоба Вэй улс тэдний довтолгооноос сэргийлэхийн тулд говийн өмнө талаар олон тооны хилийн цэрэг суулгаж, хаан нь үе үе биечлэн очиж, хянан шалгаж, эргэж тойрч байсан явдал санамсаргүй хэрэг биш байжээ.

Шэлүнь хааны үеэс эхлэн Жужан улс нь өмнөх үеийн Хүннү, Сяньби улсуудын нэгэн адил төв хэсэг, зүүн, баруун хэсэг гэсэн засаг захиргааны гурван томоохон нэгжид хуваагдан хааны засаглалд

захирагддаг байжээ. Зүүн, баруун хэсгийг Сымфа гэдэг хоёр түшмэл тус тус захирдаг байжээ. Сымфа гэдэг тэр тушаалын нэрийг зарим эрдэмтэд араб, түрэгийн шериф буюу овог, аймгийн тэргүүн гэсэн үгнээс гаралтай гэж үзэж иржээ.⁶ Жужан нарын дараа Монгол оронд мандсан түрэг, монгол угсааны нүүдэлчин улс гүрэн цөм тийнхүү гурав хуваагдаж байжээ. Төр улс засаг захиргааны байгуулал нь батлан хамгаалах цэрэг дайны зориулалттай байсан Төв Азийн нүүдэлчин улсууд стратеги-тактикийн үүднээс хүний цээж мэт ханхар том төвийн хэсэг, хоёр гар мэт зүүн, баруун захын уян хатан жигүүрүүдтэй байх уламжлалтай байжээ.

Жужаны хаант улсын төв, баруун, зүүн хэсэг нь дотроо мөн өмнөх хойтох үеийн Төв Азийн бусад нүүдэлчин улс түмний нэгэн адил мянгат, зуут, аравтын зохион байгуулалттай байжээ. Тэдгээрийг мянганы ноён, зуут, аравтын дарга нар толгойлж байсан байна.

Шэлүнь улсаа байгуулсны дараа цэрэг-захиргааны шинжтэй зарим хууль тогтоомж гаргаж, дайны үед дайсны зүг түрүүлж довтлон сайн байлдсан хүн олзны хүн ба эд юмыг бусдаас түрүүлж шилж сонгож авах, айж зугатагсад буюу ухрагсдыг цаазаар авах журам бий болгосон байна. Сайд, түшмэддээ эрхэлсэн ажлын байдал, гавъяа зүтгэлээр нь цол зэрэг олгож, шан хишиг хүртээж байжээ.

Жужаны хаант улсад Тоба Вэй улс цэрэг-стратегийн бодлогын учир зэр зэвсэг хийх төмөр худалддаггүй байсан учир Жужан нар өөрийн улсын дотор төмөр боловсруулж, сайн чанарын төмөр зэвсэг хийн хэрэглэж байжээ. Жужан төмөр боловсруулж, төмөр зэвсэг хийдэг гол төв нь Алтаны өмнө ба баруун өмнө бэлийн Ашина овогт түрэгүүдийн нутагт байжээ. Ашина овгийн 500 өрх түргүүд Жужаны хаант улсад төмөр хайлуулан төмрөөр алба барьж байсан байна.

Жужаны хаад ноёд үе улиран залгамжлагддаг байсан бөгөөд Шэлүний хаан ширээг түүний хөвгүүн Хулюй залгамжилж, 410 онд хаан болсон байна. Хулюй бас бусад аймаг овгийг байлдан эзэлж, нутгаа тэлж өргөжүүлж байжээ. Гэсэн ч 414-419 оны үед Тоба Вэй улсын зүгээс их цэрэг довтлон ирж, хүчтэй цохисон учир Датан хаан зарим цэрэг, албатаа дагуулан өрнө зүг алс хальж гарчээ. Энэ нь өрнө зүг халин гарсан Жужан нарын эхний хэсэг байжээ.

Датаны хөвгүүн Уди Жужаны хаан болоод Тоба Вэй улсын довтолгооны хариуд түүний нутагт их цэргийн хамт гүнээр цөмрөн орж нийслэл Пинчэн хотод нь аюул занал учруулж байжээ. 470 онд Тоба Вэй Юань Вэй гэгддэг болоод байсан улсын цэрэг Жужаны

нутагт түрэг орж, ялалт байгуулаад «умард зүгт цэрэглэсэн гавъяа» гэсэн үг үсэг хаданд сийлж үлдээгээд буцжээ.

Жужаны хаант улс, Тоба Вэй хоёр хоёулаа монгол угсааны улс байсан атлаа өвөр хоорондоо цөөнгүй дайн байлдаан хийж байсан боловч тэд нарын харилцааг гагцхүү дайсагналаар төсөөлөх боломжгүй байна. Тэд зарим үед худалдаа арилжаа хийж, харилцан бэлэг сэлт хүргэж, дипломат харилцаа тогтоож байсан байна. Тэд нарын хооронд шашин, соёлын харилцаа нэн далайцтай явагдаж байжээ. Шэлүнь хаан өөрөө хятад хэл бичиг сайн мэддэг, одон орон, тооны ухаанд боловсорсон хүн байсан гэж түүхэнд тэмдэглэгдэж үлджээ. Жужан нар Хятадтай харилцахдаа нанхиад гэсэн үг хэрэглэж байсан бололтой байдаг. Гэсэн ч тэд өөрийн бичигтэй байсан тухай Е.Блоше, А. Рана Таш, А. Лувсандэндэв, Г. Сүхбаатар нарын зэрэг гадаад дотоодын эрдэмтэд янз бүрийн үндэслэл нотолгоо гаргаж бичсэн байна. Тэдний ихэнх нь Жужан нар Хүннүгийн хэрэглэж байсан эртний түрэгийн рүн маягийн бичгийг уламжлан авч хэрэглэж байсан тэр бичгийг ашина овгийн түрэгүүд Жужаны мэдэлд байхдаа сурсан гэж үзэж байна.⁷ Монголч-тюркологич академич А.Лувсандэндэв рун үсэг бол түрэг угсаатны хэлэнд илүү тохирсон бичиг, харин уйгуржин үсэг нь монгол хэлэнд яв цав таарсан бичиг мөн бөгөөд XIII зууны үед төрийн бичиг болгосон уйгуржин үсгээр бичигдсэн монгол үгсийн дуудлага нь түрэгээс өмнөх үеийн монгол хэлний дуудлагыг тусгасан байна гэсэн чухал дүн шинжилгээ хийсэн байдаг.⁸ Тэгвэл түрэгээс урьд төр улс байгуулж, бичиг үсэгтэй болсон монгол угсааны Жужан, Сяньби нарыг анх арамей-согдоос үсэг авч уйгуржин монгол бичиг болгон хэрэглэсэн гэж үзэх үндэстэй гэсэн таамаглал дэвшүүлж болмоор санагдана.

Жужаны зарим хаад Хятадад элч зарж, эмч домч, хоргой нэхэгч, зүг чиг үзэх луужин, цаг уур хэмжих багаж, тэдгээрийг хийдэг дархан урьж, эмийн зүйл ирүүлэхийг хүсч байсан⁹ нь Жужан улсын соёлын харьцангуй өндөр хөгжил, Жужан Хятадын найрсаг харилцааны нотолгоо юм.¹⁰

Жужан нар онгон шүтэж тахиж, бөө мөргөл голлон зонхилоод бөө, удган нар хааны ордонд ихээхэн хүндтэй зочин болж байдаг байжээ. Бас зарим хаад нь буддийн шашинд орж, өргөө ордондоо лам нар байлгадаг байв. Жужан улсаас Тоба Вэй улсад лам хүнийг элчээр зарж, жужан лам нар мөн тэнд очиж шашны ном үзэн, Энэтхэгээс ирсэн зарим хуврагуудтай уулзаж танилцаж ярилцдаг байжээ.

Ү зууны эцэс, ялангуяа VI зууны тэргүүн хагаст Жужаны хаант улсын ноёрхолын эсрэг уйгур, түрэг, тэле зэрэг түрэг угсааны аймгууд бослого гаргаж, улам бүрий хүчтэй эсэргүүцэн тэмцэх

болжээ. Үг зууны дундуур Жужаны Анахуан хааны үед тэдний бослого хөдөлгөөн маш ширүүссэн учир Анахуан түүнтэй тэмцэж байгаад ялагдаж, амиа хорложээ. 552 онд Жужаны хаант улс Ашина овгийнхон тэргүүтэй түрэгүүдэд цохигдон - мөхөөд үлдсэн хүн ам нь түрэгийн ноёрхолд орж, 130-аад мянган хүн алс баруун зүг халин гарчээ. Хальж гарагсад нь Дундад Азиар дамжин Дорнод Европт хүрч 558 оноос хойш обор буюу авар¹¹ гэж алдаршаад Унгарт ихэнхдээ үлдсэн байна. Туркүүд Жужан нарыг обор буюу авар гэж нэрлэдэг байсан нь санамсаргүй хэрэг биш байжээ. Обор, авар гэсэн хоёр үгний аль аль нь монгол хэлэнд өөр утгаар одоо болтол байж байгаа. Обор /овор гэж том жижгийн хэмжээ, үндсэндээ нэлээд том гэсэн утгатай үг. Авар гэвэл ямарваа аюул заналаас авар гэсэн утга илтгэнэ. Энэ бүхэн хэдий сонин боловч одоогийн монголын обор, авар гэдэг өөр өөр утгатай үгийг Жужантай шууд холбон үзэж болохгүй байх аа. Харин жужан нарыг хожмын монголын татар нарын өвөг дээдэс мөн байв гэж үзэх нь үнэн байдалд илүү нийцнэ.

Зүүлт

1. Denis Sinor, Inner Asia (History-Civilization-Languages), Bloomington, 1971, pp. 97-100.
2. Мөн тэнд, 101-112.
3. Жужаны баримтын эмхэтгэл, Бээжин, 1962, 4-р тал хятадаар/
4. Мөн тэнд, 8-9-р тал.
5. Мөн тэнд, 4-р тал.
6. БНМАУ-ын түүх, гурван боть зохиол, тэргүүн боть, Улаанбаатар, 1966, 117-р тал /монголоор/
7. Г.Сүхбаатар, Монголчуудын эртний өвөг, Улаанбаатар, 1980, 115-р тал.
8. А.Лувсандэндэв. Хэл бичгийн ухааны зарим асуудал, Улаанбаатар, 1980, 12-р тал.
9. 1. Denis Sinor, Inner Asia (History-Civilization-Languages), Bloomington, 1971, pp.28.
10. Жужаны баримтын эмхэтгэл, Бээжин, 1962, 42-р тал / хятадаар,
11. Denis Sinor, Inner Asia, Pp. 145-150.

ГАДААД МОНГОЛЫН АВТОНОМИЙГ УСТГАСАН НЬ (1919 он)

Е.А.Белов

Бээжингийн «Чень бао» сонины 1919 оны 6 сарын 12-ны дугаарт «Гадаад Монголын байдлын аюул» нэртэй өгүүлэл нийтлэгдэв. Уг өгүүлэлд Хүрэн дэх амбан сайд Чень-И-гээс БНХУ ын ерөнхийлөгчид явуулсан цахилгаан утаснаас иш татаж атаман Семенов Гадаад Монгол руу аян хийж хятадын цэргийг хөөн гаргах